

ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ МЭРГЭЖИЛ, АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ, ЗААВАРЧИЛГААГААР ХАНГАСАН ТУХАЙ МЭДЭЭЛЭЛ

Орон нутгийн өмчийн газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө, газрын даргын баталсан “Сумдад ажиллах ажлын удирдамж”-ын дагуу 2023 оны 10 дугаар сарын 04-өөс 2023 оны 10 дугаар сарын 22-ны өдрүүдэд бүх сумдад худалдан авах ажиллагаа болон өмчийн бүртгэл хяналтын чиглэлээр сургалт зохион байгуулсан. Уг сургалтаар ТБОНӨХБАҮХАТХуулийн шинэчилсэн найруулгын хуулийн хүрээний бодлогын шинэчлэл, өөрчлөлт орсон зүйл заалтын танилцуулга, тэдгээрийг мөрдөж ажиллах, 2023 оны худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, алдаа дутагдлыг хянаж зөвлөгөө өгсөн. Мөн өмчийн бүртгэл хяналтын талаар төрийн байгууллагуудын удирдлага, нягтлан бодогч, өмчхамгаалах зөвлөлийн гишүүдэд сургалт зохион байгуулсан. Сургалтад нийт 395 албан хаагч хамрагдсан. Хяналтаар илэрсэн зөрчил алдаа дутагдлыг арилгах, давтан гаргахгүй байх талаар сумдад зөвлөмж хүргүүлж ажилласан.

2023.01.23-26-ны өдрүүдэд Худалдан авах ажиллагааны мэргэшсэн ажилтан бэлтгэх сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 110 хүн хамрагдаж, 74 хүн шалгалтад тэнцсэн нь 67,2 хувийг эзэлж байна.

Ажлын болон ажлын бус цагаар тендерт оролцогч 29 аж ахуй нэгжүүдэд цахим системийн хэрэглээ, тендерийн материал хэрхэн илгээх, и-токен төхөөрөмжийн бүртгэл, сунгалт болон тухайн цаг үед тулгамдаж буй асуудлуудыг нь хурдан шуурхай заавар зөвлөгөө өгч хэвшсэн.

2023.05.24-ний өдөр Боловсролын салбарын нягтлан бодогчдын сургалт, зөвлөгөөн зохион байгуулагдлаа. Тус зөвлөгөөний үеэр Худалдан авах ажиллагааны ахлах мэргэжилтэн Ч.Батболд, Өмчийн бүртгэл, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Даваадорж нар тус салбарын санхүүгийн үйл ажиллагаанд гарч байгаа ололт амжилт болон зөрчлийн талаар, цаашид анхаарах асуудлын талаар мэдээлэл өгч ажиллалаа.